



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

**Менингококкт халдвараас сэргийлэх
арга хэмжээг эрчимжүүлэх тухай**

Эрүүл мэндийн Сайдын “Менингококкт халдвартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээний заавар батлах тухай” 2008 оны 37 тоот тушаал, 2017 оны 03 дугаар сарын 10-ны “Менингококкт халдвараас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” 01 албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь

1. Тушаалыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, хийх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай


2. Иргэд үйлчлүүлэгчдэд зориулсан мэдээллийг сургалт сурталчилгааны олон хэлбэрийг ашиглан үр дүнтэй зохион байгуулахыг төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн /Б.Ууганбаяр /-д үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланг 2018 оны 03 дугаар сарын 10-ны дотор тархвар судлаач /Д.Ичинхорлоо/-д ирүүлэхийг өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.


4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга /Б.Лувсанням /-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.БОДЬЦЭЦЭГ



Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2018 оны 02 дугаар сарын 02 өдрийн
015 тоот тушаалын 01 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Нийгмийн эрүүл мэнд хариуцсан орлогч дарга Б. Лувсанням

Нарийн бичгийн дарга: Тархвар судлаач Д.Ичинхорлоо

Гишүүд: Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга Т.Гэрэлсүрэн

Өрхийн менежер Г.Даваасүрэн


Төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Б.Ууганбаяр

Тархвар судлаач С.Өлзийжаргал

Халдвартын эмч П.Төгсжаргал

Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2018 оны 12 дугаар сарын 12 өдрийн
М.С. тоот тушаалын 12 дугаар хавсралт



МЕНИНГОКОККТ ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЭРЧИМЖҮҮЛЭХЭЭР ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Хяналт тавих
1.	ЭМС-ын 2008 оны 37 тоот тушаалаар батлагдсан зааврыг мөрдөн, Менингококкт халдвартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээг авч эрчимжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах	2 сард	Тархвар судлаач	НЭМОД
2.	Менингококк халдварын сэжигтэй тохиолдлын үед үзүүлэх анхны тусламжийн эм хэрэгсэл, шинжилгээний материал, тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангах	2 сард	Тархвар судлаач, Халдвартын эмч	ЭЭОД
3.	Менингококк халдвар бүртгэгдсэн тохиолдолд голомтонд авах арга хэмжээг шуурхай зохион байгуулан, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, судалгаа тандалтыг хийж мэдээлэх	Тухай бүрт	Тархвар судлаач	НЭМОД
4.	ӨЭМТ-үүд харъяа хүүхдийн байгууллагын эмч нартай хамтран сурагч, хүмүүжигч, багш ажилчдын дунд хамар залгиурын цочмог, архаг үрэвсэлт өвчнийг илрүүлэх, эрүүлжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	2 дугаар сард	ӨЭМТ, Сургууль цэцэрлэгийн эмч нар	Тархвар судлаач
5.	Бага насны хүүхдийн гэрийн эргэлт үзлэг тандалтыг чанаржуулж эцэг эхэд өгөх заавар зөвлөмжийг чанаржуулах, сургалт зохион байгуулж үр дүнг тооцох	2-дугаар сард	ӨЭМТөв, хүүхдийн ерөнхий зохицуулагч	НЭМОД
6.	Менингококк халдварын эмнэлзүй ялган оношлогоо, эмчилгээ, голомтод хариу арга хэмжээ авах талаар эмч эмнэлгийн мэргэжилтэнд сургалт зохион байгуулах	2 дугаар сард	Халдвартын эмч	ЭЭОД
7.	Сургууль цэцэрлэг, хүүхдийн байгууллагын эмч, багш, удирдах ажилтан нарт "Менингококк халдвараас сэргийлэх" талаар сургалтыг зохион байгуулж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах	2-дугаар сард	Тархвар судлаач	НЭМОД
8.	Менингококк халдвараас урьдчилан сэргийлэх талаар иргэд үйлчлүүлэгчдэд зориулсан сурталчилгааг LED болон урсдаг дэлгэц, мэдээллийн самбар, олон нийтийн сүлжээгээр явуулж, санамж гарын авлага тараах ажлыг эрчимжүүлэх	Тогтмол	Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн	НЭМОД
9.	Менингококк халдвараас урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан ажлын үр дүн тайланг гарган холбогдох газарт гаргаж өгөх	3 сарын 10	Тархвар судлаач	НЭМОД

10.	Эмч ажилчид өдөр бүр тогтмол хоолойгоо зайлж, бүртгэл хөтлөх	2-3 дугаар сард	Тасгийн эрхлэгч, ӨЭМТ-ийн дарга нар	Тархвар судлаач
11.	Эмч, ажилчдын дунд хамар залгиурын цочмог, архаг үрэвсэлт өвчнийг илрүүлэх шинжилгээнд хамруулж, эрүүлжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	2-3 дугаар сард	Ажилчдын эмч, халдварын сэргийлэлт хяналт хариуцсан тархвар судлаач	ЭЭОД
12.	Голомтонд хэрэглэх эмийн нөөцийг бүрдүүлэх	2 дугаар сард	Эмийн сангийн эрхлэгч	ЭЭОД